

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ  
/2022.09.23-2022.12.22/**

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2022 оны 04 дүгээр улиралд нийт 45 албан бичиг ирснээс хариутай бичиг 22, хариугүй бичиг 23 байна. Удирдлагад 1, Захиргааны албанд 49, Үйлдвэрлэл, технологийн албанд 5 албан бичиг хуваарилагдан тус тус хугацаандаа, бүрэн шийдвэрлэгдсэн. Мэргэжилтнүүд хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр өөрсөддөө хуваарилагдсан албан бичгээ түргэн шуурхай, чанартай шийдвэрлэж байна.

Албан бичгийн эхийг eDoc программаар боловсруулж хэвшсэн. Албан бичгийн шийдвэрлэлтэд eDoc программын модулиудыг (эргэн танилцуулах, эргэн танилцуулах хэлбэр сонгох, хариутай бичгийн хариу сонгох, хамтран шийдвэрлэх) бүрэн ашиглахыг зорьж байна. Хариутай бичгийн шийдвэрлэлт 97.67%, хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 98.14%-тай, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3.59 хоногтой байна.

Нийслэлийн Архивын газраас өгсөн чиглэлийн дагуу, Э-токен төхөөрөмж авахад шаардлагатай бичиг баримтуудыг зааврын дагуу бүрдүүлж Газрын дарга болон Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар Үндэсний Дата төвийн баталгаажуулсан 2 тоон гарын үсгийн гэрчилгээг хүлээн авч үйл ажиллагаанд ашиглаж жигдэрсэн. Манай албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй E-token төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссан тул Бүртгэл мэдээлэл, програм хангамж хариуцсан мэргэжилтэн Ч.Баярцэцэг Үндэсний дата төвд хандаж 2022 оны сунгуулав.

Манай байгууллагаас 2022 оны 04 дүгээр улирлын байдлаар харилцан холбоотой ажилладаг яам, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад нийт 55 албан бичиг явуулсан байна.

Албан бичгийг хамгийн боломжит богино хугацаанд, чанартай шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа өмнөх оны мөн үед 2,96 байсан бол энэ онд 3,78 хоног байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн байдлыг өмнөх онтой харьцуулан харуулав.


**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧИГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

*/2022 он, 2021 оны харьцуулалт, тоон үзүүлэлтээр/*

№	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	Явуулсан бичиг
2022 он	197	87	110	3.80	190
2021 он	185	95	90	3.17	195

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

/2022 оны 04 дүгээр улирлыг, 2021 оны 04 дүгээр улирлынхтай харьцуулахад/



**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

/2022 оны 04 дүгээр улирлыг, 2021 оны 04 дүгээр улирлынхтай харьцуулахад,  
тоон үзүүлэлтээр/

№	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	Явуулсан бичиг
2022 оны 04 дүгээр улирал	45	22	23	4.22	55
2021 оны 04 дүгээр улирал	51	29	22	2.96	72

/2022 оны албан бичгийн шийдвэрлэлтийг, 4 улирлаар харьцуулахад,  
тоон үзүүлэлтээр/

№	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	Явуулсан бичиг
2022 оны 04 дүгээр улирал	54	21	23	4.23	55
2022 оны 03 дугаар улирал	44	20	24	3.91	38
2022 оны 02 дугаар улирал	61	28	33	4.56	59
2022 оны 01 дүгээр улирал	49	18	31	2.37	35

Албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил дутагдал, хугацаа хэтэрч хаагдаагүй болон хугацаа хэтэрч хаагдсан албан бичиг байхгүй.

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН  
ЗАХИРГААНЫ АЛБАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.МӨНХТОГТОХ

ТАЙЛАН ГАРГАСАН:

БИЧИГ ХЭРЭГ, АРХИВ, ГАДААД ХАРИЛЦАА  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.МӨНХДУЛАМ